

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БУТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2024 ОНЫ 5 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 6 дугаар сарын 10

Дугаар09

“ГТХЗНТ” УТУГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 5 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үнэлэлт							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	16	13	1	1	-	-	1	-	91.25
ТНУАСХ	25	22	-	3	-	-	-	-	96.40
ГХБАБМХ	8	7	1	-	-	-	-	-	98.75
Дүн	49	42	2	4	-	-	1	-	95.11

**Дүгнэлт**

Нэгжүүд 5 сард төлөвлөсөн 49 ажлын 89.8 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 10.2 хувийг хэрэгжүүлж дуусаагүй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаан тайлант сард 2 удаа хуралдаж харьяа байгууллагад нийтлэг болон тусгайлан өгсөн 7 үүрэг даалгавар биелсэн байна.

Тайлант сард хариутай 16 ирсэн албан бичиг бүртгэгдэж, 11 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх хугацаа болоогүй 3, шийдвэрлэх шатанд 1, хариу өгөөгүй 1, баримт бичиг шийдвэрлэлт 84.6 хувьтай байна.

2024.05.31-ний байдлаар төвийн хэмжээнд хариутай нийт 143 албан бичиг ирснээс шийдвэрлэлт өссөн дүнгээр 88.8 хувьтай байна.

Тайлант сард төвөөс явуулсан хариу ирүүлбэл зохих 73 албан бичиг бүртгэгдсэн ба 14 бичиг шийдвэрлэгдэж, хугацаа болоогүй 15, хариу ирээгүй 44, үүнээс шийдвэрлэх хугацаа 1-16 хоног saatсан 42 бичгийн үлдэгдэлтэй байна.

### Санал зөвлөмж

1. Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа аргачлал, Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журмыг ажилтнуудад танилцуулах, сургалт зохион байгуулах
2. Ирсэн, явуулсан албан бичиг, батлагдсан тушаал шийдвэрийг .pdf өргөтгөлөөр эйбл системийн холбогдох модульд бүрэн байршуулж бүртгэл төвлөрүүлэх
3. Сарын ажлын "хүрэх түвшин"-г шалгуур үзүүлэлтээс доогуур томьёолохгүй байх, тоон болон чанарын үзүүлэлт ашиглах, өөрөөр хэлбэл хэмжих үзүүлэлтийг тодорхой бичиж байх, нэгжийн дарга нар ажилтны төлөвлөлтийг хянан төлөвлөлтийг сайжруулах
4. ЗСХ-ийн ажилтнууд Хөдөлмөрийн дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн журамд зааснаар эйбл системээр ажлаа төлөвлөж, тайлагнах
5. Төвийн үйл ажиллагаанд 2024 оны эхний хагас жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан хяналт тавьж, биелэлтийг гаргах шаардлага бүхий дараах баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах. Үүнд:
  - a. Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө
  - b. Сайдын албан даалгавар
  - c. Сайдын тушаал
  - d. Шилэн дансны хөтлөлт
  - e. Мэдээллийн ил тод байдал
  - f. Захирлын тушаал
  - g. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө
  - h. ХАБЭА-н, хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сайдын албан даалгавар хэрэгжүүлэх, алга таших ажлын, сургалтын, монгол бичгийн, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг туслах чанараар баталсан төлөвлөгөө.

### ТАНИЛЦСАН:

"ГТХЗНТ" УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТНУАСХ-ИЙН ДАУХГ

Ж.АЛИМАА

### ХЯНАСАН:

ЗСХ-ИЙН ДАУХГ

С.ЗОЛЗАЯА

### БОЛОВСРУУЛСАН:

ХШҮМ

Э.ОСОРЖАМАА

Э.Осоржамаа  
ш/10.